

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2019 оны 12 дүгээр сарын 09 өдөр

Дугаар: 19/12/01

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ БОЛОН
ХУРЛЫГ ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит бус хуралд 11,868,539 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий 13 744 342 ширхэг энгийн хувьцааны 86.4% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 86.4%-ийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

С. ШИЖИРТУЯА

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

М. БАТБААТАР



“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2019 оны 12 дүгээр сарын 09 өдөр

Дугаар: 19/12/02

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.8 дахь заалт, 72-р зүйл, “Фронттиер Лэнд Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 12-р сарын 09-ны өдрийн ээлжит БУС хуралд санал хураалтаар ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронттиер Лэнд Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй:
 Үүнд :
 - 1.1 Компанийн үйл ажиллагааны чиглэл, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах:
Зөвшөөрсөн 9,772,648 ширхэг хувьцаа буюу 82.34%, татгалзсан 2,095,891 ширхэг хувьцаа буюу 17.66%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0% байна.
 - 1.2 Компанийн цаашид, 2019-2020 оны Компанийн бизнес төлөвлөгөөг батлах:
Зөвшөөрсөн 9,772,648 ширхэг хувьцаа буюу 82.34%, татгалзсан 2,095,891 ширхэг хувьцаа буюу 17.66%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0% байна.
 - 1.3 Компанийн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах:
Зөвшөөрсөн 9,772,648 ширхэг хувьцаа буюу 82.34%, татгалзсан 2,095,891 ширхэг хувьцаа буюу 17.66%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0% байна.
 - 1.4 Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авах тухай:
Зөвшөөрсөн 9,772,648 ширхэг хувьцаа буюу 82.34%, татгалзсан 2,095,891 ширхэг хувьцаа буюу 17.66%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0% байна.
 - 1.5 Шаардах эрх хэрэгжүүлэх тухай:
Зөвшөөрсөн 9,772,648 ширхэг хувьцаа буюу 82.34%, татгалзсан 2,095,891 ширхэг хувьцаа буюу 17.66%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0% байна.
 - 1.6 Бусад
Зөвшөөрсөн 9,772,648 ширхэг хувьцаа буюу 82.34%, татгалзсан 2,095,891 ширхэг хувьцаа буюу 17.66%, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0% байна.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

С. ШИЖИРТУЯА

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН

М. БАТБААТАР



Огноо 2019/12/09

№ 19/12/03

Улаанбаатар

ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛТЭЙ
ХЭЛЦЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 49, 87, 88, 89, 92 дугаар зүйлүүд, 2019 оны 12 сарын 09–ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
2. Тус компанийн Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Реженси Резиденс байрны 1,2,3-р давхрын түрээслэгдээгүй удаж буй өөрийн үл хөдлөх хөрөнгүүдийг зарж борлуулан шинэ үйл ажиллагаа болон хувьцаа эргүүлэн худалдан авахыг санхүүжүүлэхийг зөвшөөрсүгэй.
3. Үл хөдлөх хөрөнгийн салбарт үйл ажиллагаа явуулж байх үед буюу 2017 оны 11 сарын 15-нд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа дууссан тул сунган ажиллахыг үүрэг болгосугай.
4. Компанийн хувьцаа эзэмшигчийн гаргасан компанид хувьцаагаа эргүүлэн зарах сонирхолын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.



ХУРЛЫН ДАРГА

О. АМАРТҮВШИН

Огноо 2019/12/09

№ 19/12/01

Улаанбаатар

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2019 оны 12 сарын 09–ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд дараах үйл ажиллагааг нэмж оруулахыг зөвшөөрсүгэй. Улсын бүртгэлд буй эсвэл доорхи үйлчилгээтэй дүйх нэршилээр оруулахыг зөвшөөрсүгэй.
 - Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ
 - Менежментийн зөвлөх үйлчилгээ
 - Төслийн удирдлага
 - Програм хангамж, мэдээллийн систем хөгжүүлэлт
 - Өгөгдөл цуглуулах, боловсруулах
2. Компани үйл ажилагааныхаа чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулж, дүрмээ шинэчлэн баталж байгаатай холбогдуулан шаардах эрх үүсэж байгааг хувьцаа эзэмшигч нарт мэдэгдэж хэрэгжүүлсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулж компанийн дүрмийг шинэчлэн батлахыг зөвшөөрсүгэй.
4. Компанийн шинэчилсэн дүрмийг холбогдох эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай

ХУРЛЫН ДАРГА



О. АМАРТҮВШИН

Огноо 2019/12/09

№ 19/12/04

Улаанбаатар

КОМПАНИ ӨӨРИЙН ХУВЬЦААГАА
ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 49, 62, 88, 89-р зүйлүүд, 2019 оны 12-р сарын 09-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигчийн гаргасан саналын дагуу нийт хувьцааны 15% хувь болох 2,095,891 ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авахыг Гүйцэтгэх Удирдлагад зөвшөөрсүгэй.
2. Эргүүлэн худалдан авах хувьцааны нэгж үнийг 300 төгрөгөөр /гурван зуун төгрөгөөр/тогтоож хувьцаа худалдан авах гэрээ байгуулж, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал О.Амартүвшинд тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



О.АМАРТҮВШИН

Огноо 2019/12/09

№ 19/12/05

Улаанбаатар

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлүүд, 2019 оны 12 сарын 09–ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож амжаагүй эсвэл хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
2. Хувьцаагаа эргүүлэн Компанид зарах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хууль тогтоомжийн дагуу хувьцаа эргүүлэн авах журмыг боловсруулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан ажиллахыг Гүйцэтгэх Удирдлагад үүрэг болгосугай.
3. Төлөөлөн Удирдах Зөвлөл энэхүү ажиллагаанд хяналт тавьж ажилласугай.

ХУРЛЫН ДАРГА



О. АМАРТҮВШИН

Огноо 2019/12/09

№ 19/12/01

Улаанбаатар

ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2019 оны 12 сарын 09-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2019-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтаар баталсан төлөвлөгөөний дагуу ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Хавсралт: 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

ХУРЛЫН ДАРГА



О. АМАРТҮВШИН